

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

ЮРКОВ. С. Г. АЗИЯ В ПЛАНАХ ПЕКИНА.**М., Политиздат, 1981, 191 с.****(Маоизм-угроза человечеству)**

«Маоизм хүн төрөлхтөнд занал учруулж байна» (М., 1981) цувралд бичсэн «Ази тив бээжингийнхний төлөвлөгөөнд» гэдэг ном саяхан хэвлэгдэн гарлаа. Энэ номонд бээжингийн эрх баригчдаас Ази тивийн улс орнуудын талаар явуулж байгаа харгис бодлого, тухайлбал газар дэвсгэрийн өнгөлзлөг, тэдгээрийг хавсарган нийлүүлэх төлөвлөгөө, их гүрний жанжлах санаархлыг илчлэн харуулжээ.

Хятадын хаад ноёд 2400 жилийн тэртээ гарсан улигт «Хятад төв»-ийн үзлийн үндсэн дээр хятадыг «Дундад улс» гэж өргөмжлөн түүний тойрсон бусад улс орныг өөрийн харьяанд байх ёстой» гэдэг жанжлах санаархлыг Мао ба түүний залгамжлагчид сэргээн шинэчлээд тэдний тооцоолж буйгаар «алдагдсан газар нутаг (аль эрт хэзээ нэгэн цагт хятадын харьяанд байсан мэт) гэгчээ эргүүлж авах, өөрөөр хэлбэл бусдын газар нутгийг хүч түрэмгийлэн булаан эзлэхийг эрмэлзэж байгааг зохиогч хятадын өөрийн нь албан ёсны материалаас иш татан харуулсан байна.

«Бид дэлхийн бөмбөрцгийг байлдан дагуулах ёстой. Манай объект бол дэлхийн бөмбөрцөг. Миний бодлоор хамгийн чухал нь гэвэл бидний хүчирхэг гүрэн байгуулах дэлхийн бөмбөрцөг мөн. Ийм зориг эрмэлзлэл нэвт шингэсэн байх ёстой»¹ гэж Мао Зэдун 1959 оны есдүгээр сарын 11-нд ХКН-ын Төв Хорооны Цэргийн зөвлөлийн өргөтгөсөн хурал дээр хэлсэн бол, мөн тэрээр 1965 оны наймдугаар сард ХКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурал дээр Зүүн өмнөд Азийг булаан эзлэх программаа тодорхойлсон юм. Энэ бол их ч биш бага ч биш ердөө л бүх дэлхийг байлдан дагуулах тухай ярьж байгаа хэрэг юм. Бүх дэлхий бол тэдний эцсийн зорилго, харин түүнийг Азиас, Зүүн өмнөд хэсгээс нь эхлэхийг хятадын стратегчид зорьж байна.

Маог үхсэний дараа юу ч өөрчлөгдсөнгүй. Үүнийг «бид дайтахад хэзээ ямагт бэлэн байх ёстой, мөчийг ч алдаж болохгүй, цаг хугацаа хүлээхгүй шүү» гэж 1977 онд Хуа Гофэний хэлсэн үг нотлоно. 1975 оны нэгдүгээр сард батлагдсан хятадын үндсэн хуулийн оршилд энх тайвы тухай нэг ч үг дурдаагүй атлаа «дайнд бэлтгэх» тухай заалт оруулсныг дэлхийн олон нийт «милитаризмын тунхаглал» гэж эрс шүүмжилсэн учир хятадын удирдагчид 1978 оны хоёр, гуравдугаар сарын зааг дээр хуралдсан БХАТХ-ын чуулганаар арга буюу үг үсгийн зарим «засвар» оруулахад хүрчээ. Гэхдээ энэ нь бээжингийнхний бодлогыг энх тайванч болгоогүй. Хятад энх тайван, социализмын эсрэг эрээ цээргүй бодлогондоо газар дэвсгэрийн өнгөлзлөгөөг гол болгож байгаа бөгөөд хятадын удирдаг-

¹С. Г. Юрков. Азия в планах Пекина. М. 1981. 3-р тал

чид дэлхийн нэг ч улс орон тавьж байгаагүй тийм хэмжээний (10 гаруй сая кв км)² өнгөлзлөгийг дэлхийн нилээд хэсэгт хамруулан тавиад түүнийгээ «алдсан нутаг дэвсгэр» гэж «түүхийн үндэс»-тэй болгохыг мэрийж байна.

Үүнтэй холбогдуулан хятадын удирдагчид хэрхэн Чингис хааныг магтан сайшааж байгааг болон «Монголын ард түмнийг хятадын цөөн тоот үндэстэн» (13-р тал) болгож БНМАУ-ыг Хятадад нэгтгэх тухай Мао Зэдуны удаа дараа (1935, 1949 онуудад)-гийн хүсэл илэрхийллийг (номын 10, 51-р талууд) зохиогч илчлэн няцаажээ.

Монгол Хятадын харилцааны талаар хавсарган нийлүүлэх тухай биелээгүй мөрөөсөл гэсэн жижиг гарчгийн дор «соёлын хувьсгал», түүнээс хойших үед Бээжингийн удирдагчдаас Монголын эсрэг явуулж байсан бодлогыг манай улсын хэвлэлийн мэдээ баримтаар харуулж бичсэн байна.

Хятадын удирдагчдаас явуулж байгаа нутаг дэвсгэрийн өнгөлзлөг нь түүхийг завхруулж байгаа хэрэг бөгөөд тэд энэ өнгөлзлөгөө умард ба баруун умард тийшээ хэрэгжүүлэхэд саад бэрхшээл ихтэйг мэдээд түрэмгийллийн жолоог Зүүн өмнөд Ази руу залж түүнийг «Зөөлөн умдаг» гэж буйг зохиолд иш баримттай гаргажээ. Зүүн өмнөд Азид ноёрхохын төлөө тэнд тархсан хуацяо (цагаач иргэд) нарыг ашиглахаас эхлэн эдийн засаг, дипломат арга, эцэс сүүлд нь зэвсэгт түрэмгийлэл үйлдсэнийг 1979 онд Социалист Вьетнамд цэрэглэн халдсанаар нотолжээ.

Зохиогч «жанлах санаархал» бүлэгтээ Мао Зэдун, түүний нэгэн үзэлтний жанжлах үзлийн хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол Азийн ард түмэн бүх «гуравдахь ертөнц» гэгчид бүхэлд нь бээжингийн оройлогч болохыг хүчээр тулган хүлээлгэх гэсэн эрмэлзлэл байсан ба одоо ч байсаар байгааг Маогийн «гурван ертөнц»-ийн онол, түүний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг хор уршиг зэрэг өргөн цар хүрээтэй авч үзжээ.

Хятадын удирдагчдаас Зүүн өмнөд, мөн Өмнөд Ази (ялангуяа Энэтхэг, Афганистаны эсрэг)-д явуулж буй хагалан бутаргах үйл ажиллагааг зохиолд тодорхой харуулжээ.

Хятадын удирдагчид Өмнөд, Зүүн өмнөд Азийн орнуудын ард түмний үнэнч ханийн дүрийг үзүүлдэг байсан баг нь «соёлын хувьсгал»-ын үед илэрч улаан хамгаалагчид «Маогийн тугийг» бүх дэлхийд мандуулна гэж тангараглаж байжээ. (номын 31-р тал)

БНАСАУ-ын талаар хятад нь үнэнч бус байр суурь эзэлж байгаа (өмнөд Солонгосоос АНУ-ын цэргийг гаргах, Солонгосыг энх тайвнаар нэгтгэх зэрэг асуудлаар)-г зохиогч дүгнэж «Солонгосын асуудлаар» Бээжин америкийн империализмтай ганзага нийлэн наймаа үсэргэхээс ч буцахгүй нь уу даа гэж бодоход хүргэнэ»³ гэжээ.

«Бээжингийн түрэмгийлэгчдийн гинжинд» гэдэг тусгай гарчгийн дор зохиогч Энэтхэг хятадын хойгийн Вьетнам, Лаос, Камбож (тэр үеийн нэр)-д колоничлолын дэглэмээс чөлөөлөгдөхөд нь хятад туслаж байсан нэртэй боловч тэр нь их гүрний үзлийн үүднээс өмнө тийш гарах «түшиц» болгох, мөн энэ ч зорилгоор АНУ-ын империализмтай зв үл эвдрэх, Вьетнамыг нэгтгэж хүчирхэг болгохгүй байх зэрэг бодлого нь бүр 1954 оны Женевийн бага хурлын босгон дээр болон мөн түүнээс өмнө ч (номын 60-р тал) илэрч байсан ба ийм учраас ч социалист Вьетнамд «сургамж» үзүүлнэ гэж 1979 оны хавар Дэн Сяопин АНУ-д айлчлах үедээ хэлсэн ёсоор мөн оны хоёрдугаар сарын 17-нд БНСВУ-ын бараг бүх хилээр зэвсэглэн халдсан шившигт түрэмгийлэл нь хятадын удирдагчид Зүүн өмнөд Азийн орнуудад хэрэв тэд дагахгүй бол яадгийг сургаж сүр хүч үзүүлэх гэж ха-

²Номын 173-р тал.

³Номын 60-р тал.

райгаад «хөлөө хугалсан»-тай адил болсныг зохиогч тодорхой тайлбарлажээ,

Бээжингийн эрх баригчид зөвхөн Зүүн өмнөд Азиар зогсохгүй өргөн уудам энэ тивийн өнцөг булан бүрт өдөөн хатгаж, Энэтхэгт шүдээ зууж, Дундад дорнодод лууны сүүдэр тусгаж байгааг Афганистаны хувьсгалд дайсагнаж, шинэ залуу БНААфгУ-ын эсрэг зарлаагүй дайнд оролцож байгаа жишээгээр тусгаж харуулжээ.

«Ази тив бээжингийнхний төлөвлөгөөнд» хэмээх энэхүү ном Хятад-АНУ-ын сүлбэлдээнийг эрэмбэ дараатай авч үзээд сүүлийн үед цэргийн талаар улам даамжирч байгааг сар тутам 100-аас доошгүй төлөөлөгч солилцож байгаа баримтаар (15-р тал) дурдаж, Хятад-Японы ойртолтыг «аажим дэлбэрэх бөмбөг» гэж жишжээ.

Их гүрний санаархлаа хятадын стратегчид хэрхэн ямар замаар хэрэгжүүлэх бодлоготойн талаар зохиогч дүгнэхдээ тэд (хятадын стратегчид) гол найдлагаа дайнд тавьж байна гэжээ.⁴

НҮБ-д элссэнээс хойш 9 жил болоход энх тайвныг бэхжүүлэх талаар ганц ч бодит санал гаргаагүй хятадын удирдагчид зэвсэглэлийг хураах, олон улсын харилцааны намжмал байдлыг бэхжүүлэх, Азийн аюулгүй байдал зэрэг бүх нааштай асуудлаар сөрөг байр суурь эзэлж «Дэлхийн III дайн гарцаагүй, тэр муу ч юм биш» харин түүнийг 2000 он хүртэл түр хойшлуулж болно (175-176-р тал) гэж үзэж байгаа хятадын эрх баригчдын адал балмад гадаад бодлого нийт хүн төрөлхтөнд аюул занал учруулж байгаа ба тэдний төлөвлөгөөнд Ази тив хэрхэн тусгагдаж буйг эрдэм шинжилгээ, иш баримтын хувьд өндөр түвшинд бичсэн энэ зохиол Азийн ард түмэн, түүний дотор монголын өргөн олон уншигчдын анхаарал татах аятайхан бүтээл болжээ.

Ч. Сувд

⁴Номын 173 р тал.